

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН 2025 ОНЫ 04 ДҮГЭЭР ДҮГНЭЛТИЙГ
ХЭЛЭЛЦСЭН ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2025 оны 04 дүгээр
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсгийн холбогдох зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 04 дүгээр дүгнэлтийг 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд заасан журмын дагуу 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, итгэмжлэгдсэн төлөөлөгч Г.Уянгахишиг Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн талаар товч танилцуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар Үндсэн хуулийн цэцийн дүгнэлттэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг хэлэлцсэн үеийн хуралдааны тэмдэглэлтэй танилцаж тухайн зохицуулалтын талаар ойлголтоо бүрэн авч шийдвэр гаргах нь зүйтэй талаар, одоогийн хуулийн зохицуулалтаар сонгогч хөндлөнгийн нөлөөгүйгээр сонгох эрх олгогдсон бөгөөд ард түмний төлөөллийн байгууллага бүрэн байх зарчмыг хангахад сонгогч үүргээ хэрэгжүүлж байгаа учраас чөлөөтэй сонголт хийх эрхийг хязгаарласан гэсэн энэхүү дүгнэлтийг хэлэлцүүлгийн үед анхаарах талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээж авснаар чөлөөт сонголт хийх гэдгийн ард зарим нэгэн тойргийн төлөөлөл хаягдах магадлалтай, хүн амын жигд бус төвлөрлөөс шалтгаалж аймаг, орон нутгийн сонгогчдыг төлөөлөх төлөөллийн харьцаа алдагдах талаар тус тус үг хэлсэн болно.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсэгт “Тойрогт ногдсон мандатын тооноос ... дутуу нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн ... саналын хуудсыг хүчингүйд тооцно.” гэж заасны “... дутуу ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд ... чөлөөтэй ... сонгох эрхийн үндсэн дээр ... сонгоно.” гэснийг зөрчсөн байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 04 дүгээр дүгнэлтийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 04 дүгээр дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**

Ж.БАТ-ЭРДЭНЭ

